



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Хүрээмарал сумын Засаг даргын Тамгын газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Аудитын код: БНА-2022/82/НА-СТА-ТШЗ

Баянхонгор
2022 он

Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,
Тэргүүлэх аудитор: Б.Мөнхбат

Утас: 99007576 Цахим хаяг: munkhbatb@audit.gov.mn

Аудитын менежер: А.Цээням

Утас: 99442140 Цахим хаяг: tseenyama@audit.gov.mn

Аудитор: Б.Нарангэрэл

Утас: 99009293 Цахим хаяг: Narangerelb@audit.gov.mn

Цахим хуудас: www.audit.mn

Агуулга

1. Аудитын санал дүгнэлт.....	2
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл.....	3
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан.....	3
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан.....	4
2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	5
2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан.....	6
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	6
3. Аудитын тайлан.....	9
3.1 Ерөнхий зүйл.....	9
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт.....	9
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал.....	9
3.4 Материаллаг байдал.....	10
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга.....	10
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв.....	11
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг.....	12
3.8 Аудитын гол асуудал.....	12
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал.....	13
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт.....	13
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	14
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	14
4. Аудитын илрүүлэлт.....	14
4.1 Залруулсан алдаа.....	Error! Bookmark not defined.
4.2 Төлбөрийн акт.....	Error! Bookmark not defined.
4.3 Албан шаардлага.....	14
4.3 Зөвлөмж.....	15
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл.....	17

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар



**БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

Номгон 1 дүгээр баг, Баянхонгор сум,

Баянхонгор аймаг, 64101

Утас, факс 7044 2584

E-mail; bayankhongor@audit.gov.mn

2022.02.25 № 2175

танай _____ -ны № _____ -т

АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Хүрээмарал сумын Засаг даргын Тамгын газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Хүрээмарал сумын Засаг даргын Тамгын газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторовын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторовын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Аудитын гол асуудал

Хүрээмарал сумын Засаг даргын Тамгын газрын 2021 оны санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн зөрчлийн дүн бидний тооцсон материаллаг байдлын түвшнээс давсан, мөн АДБОУС 1240 (АОУС 240) дагуу сонгосон горим сорилоор доорх алдаа зөрчил илэрсэн нь "Хязгаарлалттай" дүгнэлт өгөх үндэслэл болно. Үүнд:

- Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн авлагыг барагдуулах албан шаардлагыг бүрэн хэрэгжүүлээгүй.

- Засаг даргын нөөц хөрөнгийн зарцуулалтын тайланг гаргаж, үр дүнг тооцоогүй.

Дээрх зөрчлүүд нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8 "Төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх", 41 дүгээр зүйлийн 41.2.7 дахь "хөтөлбөрийн хэрэгжилтэд хяналт тавих, хүрэх үр дүнг хангаж ажиллах", Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалаар баталсан "Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам"-ын 6.2 дахь "Нөөц хөрөнгийн зарцуулалтын тайланг санхүүжүүлсэн зардал, арга хэмжээг хэрэгжүүлэх төлөвлөгөө, төсөвтэй зэрэгцүүлэн гаргаж, байгууллагын дарга, нягтлан

бодогч нар гарын үсэг зурж, тамга, тэмдэг дарж баталгаажуулан холбогдох баримтыг хавсаргана” гэсэн заалттай нийцэхгүй, санхүүгийн тайлагналын “Эрх ба үүрэг”, “Нийцсэн бөгөөд зохистой байх”, “Иж бүрэн байх” гэсэн батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.


Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР



Б.МӨНХБАТ

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Код	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	117,217,111.22	70,364,611.22
33	АВЛАГА	7,066,881.22	8,195,881.22
33500	Бусад авлага	7,066,881.22	8,195,881.22
33510	Байгууллагаас авах авлага	7,066,881.22	8,195,881.22
35	БАРАА МАТЕРИАЛ	40,616,430.00	55,011,230.00
35400	Хангамжийн материал	36,551,430.00	48,341,230.00
35410	Бичиг хэргийн материал	1,912,475.00	1,912,475.00
35450	Барилгын засварын материал	459,000.00	459,000.00
35470	Бусад хангамжийн материал	34,179,955.00	45,969,755.00
35600	Мал амьтад	4,065,000.00	6,670,000.00
36	НӨӨЦИЙН БАРАА	69,533,800.00	7,157,500.00
36300	Тэжээлийн нөөц	69,533,800.00	7,157,500.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	1,255,028,199.55	1,174,260,486.87
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	1,255,028,199.55	1,174,260,486.87
39200	Биет хөрөнгө	1,240,570,699.55	1,159,952,986.87
39201	Барилга, байгууламж, орон сууц	1,492,944,846.00	1,492,944,846.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	-427,029,269.40	-483,104,739.88
39203	Авто-тээврийн хэрэгсэл	165,084,800.00	165,084,800.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-84,871,149.92	-100,581,949.88
39205	Машин тоног төхөөрөмж(компьютер)	135,471,112.03	143,764,112.03
39206	Хуримтлагдсан элэгдэл	-96,358,482.26	-109,182,640.24
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	148,331,533.99	156,671,533.99
39208	Хуримтлагдсан элэгдэл	-100,617,690.89	-113,557,975.15
39216	Дуусаагүй барилга, байгууламж	7,400,000.00	7,400,000.00
39217	Ном	215,000.00	515,000.00
39300	Биет бус хөрөнгө	14,457,500.00	14,307,500.00
39301	Програм хангамж	1,420,000.00	1,420,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-782,500.00	-932,500.00
39303	Бусад биет бус хөрөнгө	13,820,000.00	13,820,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	1,372,245,310.77	1,244,625,098.09
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	0	14,569,350.00
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	0	14,569,350.00
41300	Өглөг	0	14,569,350.00
41320	Бараа үйлчилгээний зардлын өглөг	0	9,053,810.00
41360	Бусад өглөг	0	5,515,540.00
41361	Байгууллагад төлөх өглөг	0	5,515,540.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	1,372,245,310.77	1,230,055,748.09
51	Засгийн газрын хувь оролцоо	1,372,245,310.77	1,230,055,748.09
51100	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	916,547,429.40	916,547,429.40
51200	Хуримтлагдсан үр дүн	290,646,903.90	148,457,341.22
51210	Өмнөх үеийн үр дүн	298,637,809.62	290,646,903.90
51220	Тайлант үеийн үр дүн	-7,990,905.72	-142,189,562.68
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	165,050,977.47	165,050,977.47
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	1,372,245,310.77	1,244,625,098.09

Хүрээмарал сумын Засаг даргын Тамгын газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	533,110,306.00	493,336,541.50
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	85,385,920.00	80,811,000.00
120	Нийтлэг татварын бус орлого	85,385,920.00	80,811,000.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	85,385,920.00	350,000.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	84,000.00	350,000.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	84,545,920.00	0
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	0	12,433,000.00
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал	0	68,028,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	447,724,386.00	412,525,541.50
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	9,956,686.00	13,299,441.50
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	9,956,686.00	13,299,441.50
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	437,767,700.00	399,226,100.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	437,767,700.00	399,226,100.00
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	541,101,211.72	635,526,104.18
21	УРСГАЛ ЗАРДАЛ	541,101,211.72	635,526,104.18
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	483,442,553.72	612,399,137.18
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	233,561,843.00	212,183,754.00
210101	Үндсэн цалин	189,112,697.00	181,179,659.00
210102	Нэмэгдэл	44,449,146.00	30,398,295.00
210105	Гэрээт ажлын хөлс	0	605,800.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	29,430,250.00	27,253,025.00
210201	Тэтгэврийн даатгал	20,495,012.00	18,941,596.00
210202	Тэтгэмжийн даатгал	2,337,994.00	2,123,385.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,870,396.00	1,673,463.00
210204	Ажилгүйдлийн даатгал	425,029.00	410,465.00
210205	Эрүүл мэндийн даатгал	4,301,819.00	4,104,116.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	20,343,395.00	23,544,980.00
210301	Гэрэл, цахилгаан	3,706,048.00	4,823,860.00
210302	Түлш, халаалт	16,637,347.00	18,721,120.00
2104	Хангамж, бараа материалын зардал	31,620,372.00	36,681,262.00
210401	Бичиг хэрэг	3,521,700.00	3,348,450.00
210402	Тээвэр, шатахуун	24,587,125.00	28,034,840.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	980,547.00	1,120,872.00
210404	Ном, хэвлэл	658,600.00	50,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	360,000.00	0
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,512,400.00	62,100.00
210408	Бараа материал акталсны зардал	0	4,065,000.00
2105	Нормативт зардал	781,400.00	1,347,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	781,400.00	1,347,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	28,465,568.00	225,500.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	28,015,568.00	0
210604	Урсгал засвар	450,000.00	225,500.00
2107	Томилолт, зочны зардал	4,522,000.00	6,964,000.00
210702	Дотоод албан томилолт	4,522,000.00	6,964,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	19,248,868.00	147,204,401.50
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	14,473,136.00	142,488,821.50
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	250,000.00	350,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	522,500.00	396,500.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	234,152.00	230,000.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	150,000.00	120,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	3,564,000.00	3,564,000.00
210807	Газрын төлбөр	55,080.00	55,080.00

Хүрээмарал сумын Засаг даргын Тамгын газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

2109	Бараа үйлчилгээний бусад зардал	115,468,857.72	156,995,214.68
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	11,756,700.00	58,300,702.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	2,490,900.00	993,800.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	101,221,257.72	97,700,712.68
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	57,658,658.00	23,126,967.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	56,003,265.00	1,499,431.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	52,721,300.00	0
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	3,281,965.00	1,499,431.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	1,655,393.00	21,627,536.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	55,393.00	21,498,536.00
213405	Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	1,600,000.00	129,000.00
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	-7,990,905.72	-142,189,562.68
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	-7,990,905.72	-142,189,562.68

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	448,564,386.00	412,875,541.50
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	840,000.00	350,000.00
120	Нийтлэг татварын бус орлого	840,000.00	350,000.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	840,000.00	350,000.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	840,000.00	350,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	447,724,386.00	412,525,541.50
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	9,956,686.00	13,299,441.50
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	9,956,686.00	13,299,441.50
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	437,767,700.00	399,226,100.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	437,767,700.00	399,226,100.00
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	419,652,386.00	408,375,541.50
21	УРСГАЛ ЗАРДАЛ	419,652,386.00	408,375,541.50
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	361,453,728.00	385,248,574.50
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	233,561,843.00	212,208,629.00
210101	Үндсэн цалин	189,112,698.15	181,016,126.00
210102	Нэмэгдэл	44,449,144.85	30,586,703.00
210105	Гэрээт ажлын хөлс	0	605,800.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	29,430,250.00	27,228,150.00
210201	Тэтгэврийн даатгал	20,495,012.00	18,916,778.00
210202	Тэтгэмжийн даатгал	2,337,994.00	2,123,349.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,870,396.00	1,673,450.00
210204	Ажилгүйдлийн даатгал	425,029.00	410,465.00
210205	Эрүүл мэндийн даатгал	4,301,819.00	4,104,108.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	20,343,395.00	23,544,980.00
210301	Гэрэл, цахилгаан	3,706,048.00	4,823,860.00
210302	Түлш, халаалт	16,637,347.00	18,721,120.00
2104	Хангамж, бараа материалын зардал	33,220,372.00	27,077,252.00
210401	Бичиг хэрэг	3,521,700.00	3,123,900.00
210402	Тээвэр, шатахуун	24,587,125.00	22,509,030.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	980,547.00	1,128,022.00
210404	Ном, хэвлэл	658,600.00	50,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	360,000.00	0
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	3,112,400.00	266,300.00
2105	Нормативт зардал	781,400.00	1,347,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	781,400.00	1,347,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	445,000.00	2,154,300.00
210604	Урсгал засвар	445,000.00	2,154,300.00
2107	Томилолт, зочны зардал	4,522,000.00	3,436,000.00
210702	Дотоод албан томилолт	4,522,000.00	3,436,000.00

Хүрээмарал сумын Засаг даргын Тамгын газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	19,253,868.00	16,286,021.50
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	14,478,136.00	11,570,441.50
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	250,000.00	350,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	522,500.00	396,500.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	234,152.00	230,000.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	150,000.00	120,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	3,564,000.00	3,564,000.00
210807	Газрын төлбөр	55,080.00	55,080.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	19,895,600.00	71,966,242.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	17,404,700.00	70,966,242.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	2,490,900.00	1,000,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	58,198,658.00	23,126,967.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	56,543,265.00	1,499,431.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	52,721,300.00	0
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	3,821,965.00	1,499,431.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	1,655,393.00	21,627,536.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	55,393.00	21,498,536.00
213405	Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	1,600,000.00	129,000.00
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	28,912,000.00	4,500,000.00
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	28,912,000.00	4,500,000.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	28,912,000.00	4,500,000.00
2200	Дотоод эх үүсвэрээр	28,912,000.00	4,500,000.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	28,912,000.00	4,500,000.00
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	-28,912,000.00	-4,500,000.00
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0	0
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0	0

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
1	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	916,547,429.40	165,050,977.47	298,637,809.62	1,380,236,216.49
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	916,547,429.40	165,050,977.47	298,637,809.62	1,380,236,216.49
9	Тайлант үеийн үр дүн	0	0	-7,990,905.72	-7,990,905.72
10	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	916,547,429.40	165,050,977.47	290,646,903.90	1,372,245,310.77
11	2021 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	916,547,429.40	165,050,977.47	290,646,903.90	1,372,245,310.77
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	916,547,429.40	165,050,977.47	290,646,903.90	1,372,245,310.77
19	Тайлант үеийн үр дүн	0	0	-142,189,562.68	-142,189,562.68
20	2021 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл	916,547,429.40	165,050,977.47	148,457,341.22	1,230,055,748.09

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Төсвийн гүйцэтгэлийн тайлан	Зөрүү	Хувь
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	416,795,800.00	378,077,564.00	38,718,236.00	90.7
21	УРСГАЛ ЗАРДАЛ	416,795,800.00	378,077,564.00	38,718,236.00	90.7
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	415,295,800.00	376,578,133.00	38,717,667.00	90.7
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	231,363,400.00	212,208,629.00	19,154,771.00	91.7
210101	Үндсэн цалин	184,026,600.00	181,016,126.00	3,010,474.00	98.4
210102	Нэмэгдэл	43,701,800.00	30,586,703.00	13,115,097.00	70.0
210105	Гэрээт ажлын хөлс	3,635,000.00	605,800.00	3,029,200.00	16.7

Хүрээмарал сумын Засаг даргын Тамгын газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	31,234,000.00	27,228,150.00	4,005,850.00	87.2
210201	Тэтгэврийн даатгал	21,979,500.00	18,916,778.00	3,062,722.00	86.1
210202	Тэтгэмжийн даатгал	2,313,600.00	2,123,349.00	190,251.00	91.8
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,850,900.00	1,673,450.00	177,450.00	90.4
210204	Ажилгүйдлийн даатгал	462,800.00	410,465.00	52,335.00	88.7
210205	Эрүүл мэндийн даатгал	4,627,200.00	4,104,108.00	523,092.00	88.7
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	24,760,100.00	23,544,980.00	1,215,120.00	95.1
210301	Гэрэл, цахилгаан	5,846,300.00	4,823,860.00	1,022,440.00	82.5
210302	Түлш, халаалт	18,913,800.00	18,721,120.00	192,680.00	99.0
2104	Хангамж, бараа материалын зардал	36,146,500.00	29,910,952.00	6,235,548.00	82.7
210401	Бичиг хэрэг	3,123,900.00	3,123,900.00	0.00	100.0
210402	Тээвэр, шатахуун	22,509,300.00	22,509,030.00	270.00	100.0
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	973,300.00	1,128,022.00	-154,722.00	115.9
210404	Ном, хэвлэл	700,000.00	350,000.00	350,000.00	50.0
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	6,240,000.00	0	6,240,000.00	0.0
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,600,000.00	2,800,000.00	-200,000.00	107.7
2105	Нормативт зардал	1,347,000.00	1,347,000.00	0.00	100.0
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,347,000.00	1,347,000.00	0.00	100.0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	2,154,300.00	2,154,300.00	0.00	100.0
210604	Урсгал засвар	2,154,300.00	2,154,300.00	0.00	100.0
2107	Томилолт, зочны зардал	6,031,000.00	3,436,000.00	2,595,000.00	57.0
210702	Дотоод албан томилолт	6,031,000.00	3,436,000.00	2,595,000.00	57.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	4,759,500.00	4,715,580.00	43,920.00	99.1
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	350,000.00	350,000.00	0.00	100.0
210803	Даатгалын үйлчилгээ	396,500.00	396,500.00	0.00	100.0
210804	Тээврийн хэрэгслийн татвар	230,000.00	230,000.00	0.00	100.0
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	120,000.00	120,000.00	0.00	100.0
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	3,564,000.00	3,564,000.00	0.00	100.0
210807	Газрын төлбөр	99,000.00	55,080.00	43,920.00	55.6
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	77,500,000.00	72,032,542.00	5,467,458.00	92.9
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	76,500,000.00	71,032,542.00	5,467,458.00	92.9
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,000,000.00	1,000,000.00	0.00	100.0
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1,500,000.00	1,499,431.00	569.00	100.0
2132	Бусад урсгал шилжүүлэг	1,500,000.00	1,499,431.00	569.00	100.0
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,500,000.00	1,499,431.00	569.00	100.0
III	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	416,795,800.00	399,576,100.00	17,219,700.00	95.9
32	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	415,795,800.00	399,226,100.00	16,569,700.00	96.0
320001	Орон нутгийн төсвөөс	415,795,800.00	399,226,100.00	16,569,700.00	96.0
35	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	1,000,000.00	350,000.00	650,000.00	35.0
350002	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1,000,000.00	350,000.00	650,000.00	35.0
6	ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ	43	41		
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	1	1		
610001	Төсвийн байгууллага	1	1		
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	21	20		
620001	Удирдах ажилтан	8	8		
620002	Гүйцэтгэх ажилтан	11	10		
620003	Үйлчлэх ажилтан	2	2		
65	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	21	20		
650001	Төрийн захиргааны албан хаагч (ТЗ)	8	8		
650009	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	6	5		
650011	Улс төрийн албан хаагч (УТ)	7	7		

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Гүйцэтгэл
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	11,240,686.00	13,299,441.50
21	УРСГАЛ ЗАРДАЛ	11,240,686.00	13,299,441.50
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	11,240,686.00	13,299,441.50
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	9,640,686.00	13,170,441.50
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	9,640,686.00	13,170,441.50
2133	Олгосон санхүүжилт, шилжүүлэг	1,600,000.00	129,000.00
213503	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, төвлөрүүлэх шилжүүлэг	1,600,000.00	129,000.00
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	11240686.00	13299441.50
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	11,240,686.00	13,299,441.50
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	10,796,686.00	12,949,441.50
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	444,000.00	350,000.00
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0.00	0.00
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0.00	0.00

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Хүрээмарал сумын Засаг даргын Тамгын газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Б.Нарангэрэл гүйцэтгэж, чанарын хяналтыг ахлах аудитор М.Алтантуяа, аудитын менежер А.Цээням, Газрын дарга, тэргүүлэх аудитор Б.Мөнхбат нар тус тус хэрэгжүүлсэн.

Хүрээмарал сумын Засаг даргын Тамгын газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлгэх хүсэлтийг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 01 дүгээр сарын 25-ны өдөр ирүүлсэн ба төсвийн зарцуулалтад нэгдүгээр гарын үсгийг дарга С.Нархүү, хоёрдугаар гарын үсгийг нягтлан бодогч Б.Баттөмөр нар зурсан байна.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Хүрээмарал сумын Засаг даргын Тамгын газрын зорилго, зорилт, үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

Оновчтой бодлого, төлөвлөлтөөр хэрэгжилтийг хангах замаар аймгийнхаа хөгжилд дэмжлэг үзүүлж чаддаг, цомхон, чадварлаг, эцсийн үр дүнг эрхэмлэн дээдэлсэн төрийн албыг төлөвшүүлэхэд оршино.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Баянхонгор аймгийн Санхүүгийн хяналт, дотоод аудитын алба нь дотоод аудитын чиг үүргийг хэрэгжүүлдэг ба Хүрээмарал сумын Засаг даргын Тамгын газрын 2021 оны санхүүгийн үйл ажиллагаанд дотоод аудит хийгдээгүй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 САНХҮҮГИЙН ТАЙЛАГНАЛЫН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Хүрээмарал сумын Засаг даргын Тамгын газрын 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл “Дунд” гэж үнэлэн материаллаг байдлын түвшнийг 1.5 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны үр дүнгийн тайлангийн нийт зардал 541,101.2 мянган төгрөгөөс 1.5 хувиар буюу 8,116.5 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 70 хувиар буюу 5,681.6 мянган төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг гүйцэтгэлийн үе шатанд хянаж үзээд, 2021 оны үр дүнгийн тайлангийн нийт зардлаас тооцоход гүйцэтгэлийн материаллаг байдал 6,673.0 мянган төгрөг байгаа тул, шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Хүрээмарал сумын Засаг даргын Тамгын газрын 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 127,620.0 мянган төгрөгөөр буюу 10.3 хувиар буурсан байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан авлага, бараа материал, үндсэн хөрөнгө, өглөгийн данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт /мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	117,217.1	70,364.6	(46,852.5)
Мөнгөн хөрөнгө	-	-	-
Авлага	7,066.9	8,195.9	1,129.0
Урьдчилгаа	-	-	-
Бараа материал	110,150.2	62,168.7	(47,981.5)
ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	1,255,028.2	1,174,260.5	(80,767.7)
Үндсэн хөрөнгө	1,964,687.3	1,981,620.3	16,933.0
Хуримтлагдсан элэгдэл	(709,659.1)	(807,359.8)	(97,700.7)
Нийт хөрөнгө	1,372,245.3	1,244,625.1	(127,620.2)
Өр төлбөр	-	14,569.4	14,569.4
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	1,372,245.3	1,230,055.7	(142,189.6)
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	1,372,245.3	1,244,625.1	(127,620.2)

Авлагын дансны үлдэгдэл 8195.9 мянган төгрөг болж 1,129.0 мянган төгрөгөөр нэмэгдсэн нь өмнөх онд үүссэн моторын түрээсийн авлага, мөн нэмэлт санхүүжилтийн дансны зарцуулагдаагүй үлдэгдэл болох 129.0 мянган төгрөгийг тайлант оны авлагаар бүртгэсэн, Марал гурван очир ХХК-тай байгуулсан 5000.0 мянган төгрөгийн худгийн

цахим картын тоног төхөөрөмжийг нийлүүлээгүй тул тайлант хугацааны авлагаар бүртгэсэнтэй тус тус холбоотой байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 62,168.7 мянган төгрөг болж 47,981.5 мянган төгрөгөөр буурсан нь бусад хангамжийн материал 11,789.8 мянга, мал амьтад 2,605.0 мянган төгрөгөөр өссөн бөгөөд, тэжээлийн нөөц данснаас 62,376.3 мянган төгрөгийн өвс тэжээл зарцуулсан нь голлох нөлөөг үзүүлжээ.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 1,981,620.3 мянган төгрөг болж өмнөх оноос 16,933.0 мянган төгрөгөөр өссөн нь 4,500.0 мянган төгрөгийн хөрөнгө төсвийн хөрөнгөөр худалдан авч, аймгийн ИТХ-ын тэргүүлэгчдийн 2021.10.15-ны өдрийн 115 дугаар тогтоолоор 4,763.0 мянган төгрөгийн тоног төхөөрөмж, ОНХС-ийн хөрөнгөөр хийсэн 7670.0 мянган төгрөгийн эд хөрөнгийг үнэ төлбөргүй хүлээн авсантай холбоотой байна.

Өглөгийн дансны үлдэгдэл 14,569.4 мянга болж өссөн нь тайлант хугацаанд тус суманд малын гоц халдварт шүлхий өвчин гарсантай холбоотойгоор тээвэр шатахууны өглөг 5525.8 мянга, постод ажилласан хүмүүст өгөх томилолтын өглөг 3,528.0 мянга, хүнсний материалын өглөг 5,515.5 мянган төгрөгөөр нэмэгдсэн байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 1,230,055.7 мянган төгрөг болж 142,189.6 мянган төгрөгөөр буурсан нь тайлант үеийн үр дүн 142,189.6 мянган төгрөгийн өөрчлөлтөөс шалтгаалжээ.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2021 оны төсвийн төсөлд төсвийн нийт зарлагыг 395,411.1 мянга, санхүүжүүлэх эх үүсвэрийг 395,411.1 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс 42,302.4 мянган төгрөгөөр бууруулж 353,108.7 мянган төгрөгөөр анх батлагдсан бөгөөд тайлант хугацаан 1 удаа тодотгол хийж 416,795.8 мянган төгрөгөөр батлагдсан байна.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 6 арга хэмжээг 416,795.8 мянган төгрөгөөр санхүүжүүлэхээр төлөвлөж гүйцэтгэлээр орон нутгийн төсвөөс 415,795.8 мянган төгрөгийн санхүүжилт авч, өөрийн орлогоор 350.0 мянган төгрөгийн орлого бүрдүүлж, урсгал үйл ажиллагаанд 378,077.6 мянган төгрөгийг зарцуулж 21,498.5 мянган төгрөгийг орон нутгийн төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 378,077.6 мянган төгрөг буюу 90.7 хувьтай байгаа нь цалин хөлс нэмэгдэл урамшлын зардлыг 19,154.8 мянга, ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл 4,005.9 мянга, байр ашиглалттай холбоотой тогтмол зардлыг 1215.1 мянга, хангамж бараа материалын зардлыг 6,235.5 мянга, томилолтын зардлыг 2,595.0 мянга, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр хураамж 43.9 мянга, бараа үйлчилгээний бусад зардал 5,467.5 мянган төгрөгөөр тус тус хэмнэсэн нь голлох нөлөөг үзүүлж байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Тус байгууллагын 2021 оны санхүүгийн тайлангийн завсрын аудитаар нягтлан бодох бүртгэлтэй холбоотой дараах алдаа, зөрчил илэрсэн ба тус алдаа, зөрчлүүдийг жилийн эцсийн санхүүгийн тайлангийн аудитаар арилгаж нягтлан бодох бүртгэлийг холбогдох стандартын дагуу бүртгэсэн байна. Үүнд:

- Тайлант хугацаанд нэмэлт санхүүжилтийн харилцах дансаар хийгдсэн 3000.0 мянган төгрөгийн орлогын гүйлгээг нягтлан бодох бүртгэлд бүртгээгүйгээс санхүүгийн программ дахь мөнгөн хөрөнгийн үлдэгдэл зөрүүтэй байна. Тайлант хугацаанд нэмэлт санхүүжилтийн харилцах дансаар хийгдсэн 2386.0 мянган төгрөгийн автомашины засварын үлдэгдлийг буцаан төвлөрүүлсэн гүйлгээг нягтлан бодох бүртгэлд бүртгээгүйгээс санхүүгийн программ дахь мөнгөн хөрөнгийн үлдэгдэл зөрүүтэй.
- Засаг даргын 2021.03.19-ны өдрийн А/37 дугаар захирамжаар сумын төвийн нохой устгахад 540.0 мянган төгрөгийг Засаг даргын нөөц хөрөнгөнөөс зарцуулах шийдвэр гарсан ч уг хөрөнгийг үндсэн үйл ажиллагааны бараа үйлчилгээний бусад зардлаас зарцуулсан байна. Сангийн яамны Э-тайланд шивж баталгаажуулсан 3-р улирлын санхүүгийн байдлын тайланг санхүүгийн программд бүртгэсэн тайлантай тулган шалгахад эцсийн үлдэгдэл 256.9 мянган төгрөгөөр зөрүүтэй байна.
- Санхүүгийн тайланд байгаа эргэлтийн хөрөнгийн үлдэгдлийг эд хариуцагчийн тайлантай тулган шалгахад нярав түлш шатахууны тайлан гаргаагүй, хүнс, бусад хангамж, нөөцийн барааны тайланг зөрүүтэй гаргаснаас нийт орлого 31436.9 мянга, зарлага 43495.2 мянга, эцсийн үлдэгдэл нь 12058.3 мянган төгрөгөөр зөрүүтэй байна. Мал тооллогын тоологчийн цалинг НДХ-т мэдээлээгүйгээс нийт 382.3 мянган төгрөгийн зөрүү үүссэн, мөн ХХОАТ 72.5 мянга, НД-д 91.9 мянган төгрөгийг санхүүгийн тайланд зөрүүтэй тусгасан.
- Ажиллагсдын цалингийн санг 2-9 дүгээр саруудад НДХ-т нийт 3881.6 мянган төгрөгөөр зөрүүтэй мэдээлсэн байна.
- Цалингийн зардлыг санхүүгийн программд тухай бүр үнэн зөв хөтлөөгүй, ажил олгогчоос төлөх нийгмийн даатгалын шимтгэлийг цалингийн сангаас шилжүүлсэн зэргээр цалингийн зардлыг 4260.8 мянган төгрөгөөр зөрүүтэй бүртгэсэн зэрэг зөрчил гарсныг арилгасан байна.

Тус байгууллагын 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Н.Бунчинсүрэн санхүүгийн тайлангийн аудит хийсэн бөгөөд тайлант оны санхүүгийн тайлангийн аудитаар өмнөх оны санхүүгийн тайлангийн мэдээллийг хамруулаагүй болно.

Байгууллагын жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 13 зорилтын хүрээнд нийт 76 арга хэмжээ хэрэгжүүлэхээр төлөвлөж 96.1 хувийн гүйцэтгэлтэй гэж тайлагнасан байна.

3.8 Аудитын гол асуудал

Тус байгууллагын санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт зардал 635,526.1 мянган төгрөг байгаа нь өмнөх оноос 94,424.8 мянган төгрөгөөр буюу 17.5 хувиар өссөн байна.

Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан зардлууд байр ашиглалттай холбоотой тогтмол зардал, хангамж бараа материалын зардал, нормативд зардал, дотоод албан томилолтын зардал, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр хураамжийн зардал, бараа үйлчилгээний бусад зардал өмнөх оноос нэмэгдсэн байгаа бол

цалин хөлс болон нэмэгдэл урамшил, ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл, эд хогшил худалдан авах зардал, нь өмнөх оноос буурсан үзүүлэлттэй байна.

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2021 оны А/108 дугаар тушаалаар баталсан "Төрийн аудитын байгууллагаас шилэн дансны 2021-2022 оны үйл ажиллагаанд хөндлөнгийн хяналтыг хэрэгжүүлэх ерөнхий чиглэл"-ийн 1 дүгээр хавсралтад заасан 10 төрлийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Тус байгууллага нь 2021 онд нийт 543,336.1 мянган төгрөгийн 45 мэдээллээс хуулийн 6.1.4-д заасан хагас жилийн санхүүгийн тайлан, 6.4.5-д заасан таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 12568.2 мянган төгрөгийн зарлагын 1 гүйлгээ, орлогын 35432.9 мянган төгрөгийн 2 гүйлгээг хугацаа хоцроож, 6.4.5-д заасан таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 44309.6 мянган төгрөгийн зарлагын 4 гүйлгээг тус тус мэдээлээгүй байна.

3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Засгийн газрын 2021 оны "Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай" 43 дугаар тогтоолын хэрэгжилт

Байгууллагын төсвийн хөрөнгийн зарцуулалтад тогтоолын хэрэгжилтийг шалгахад дараах байдалтай байна. Үүнд:

- 2021 оны төсвийг 353,108.7 мянган төгрөгөөр анх баталсан ба тодотголоор 62,687.1 мянган төгрөг нэмж 415,795.8 мянган төгрөгийг орон нутгийн төсвөөс, 1,000.0 мянган төгрөгийг төсөвт байгууллагын өөрийн орлогоор санхүүжүүлэхээр баталсан ба гүйцэтгэлээр 378,077.6 мянган төгрөг зарцуулж, орон нутгийн төсөвт 21,498.5 мянган төгрөгийг буцаан төвлөрүүлсэн байгаа нь нийт зардлын 5.2 хувийг хэмнэсэн гэж үзэхээр байна.

Энэ нь Засгийн газрын 2021 оны "Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай" 43 дугаар тогтоолын 1.1¹ гэсэн заалттай нийцэхгүй байна.

- Бичиг хэргийн зардлыг 3,123.9 мянган төгрөгөөр баталснаас гүйцэтгэлээр 3,123.9 мянган төгрөг зарцуулсан байгаа нь Засгийн газрын 2021 оны "Төсвийн хэмнэлтийн

1. Үндсэн үйл ажиллагаатай холбоотой, зайлшгүй шаардлагатайгаас бусад бүх төрлийн зардал, төсөл, арга хэмжээг тэвчиж, зардлыг гаргахгүй байх зэргээр батлагдсан

талаар авах арга хэмжээний тухай" 43 дугаар тогтоолын 1.9² гэсэн заалттай нийцэхгүй байна.

-Албан томилолтын зардлыг 6,031.0 мянган төгрөгөөр баталж гүйцэтгэлээр 3,436.0 мянган төгрөг зарцуулсан нь батлагдсан төсөвт 43.0 хувийн хэмнэлт гаргасан.

- Байгууллагын ашиглалттай холбоотой тогтмол зардлын төсвийг анх 14,292.0 мянган төгрөгөөр, тодотголоор 24,760.1 мянган төгрөгөөр баталж, гүйцэтгэлээр 23,544.9 мянган төгрөг зарцуулж, анх баталсан дүнгээс 9,252.9 мянган төгрөг буюу 64.7 хувиар нэмэгдүүлсэн нь Засгийн газрын 2021 оны "Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай" 43 дугаар тогтоолын 1.8³ дахь заалттай нийцэхгүй байна.

3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар нийт 19,261.7 мянган төгрөгийн 5 алдаа зөрчил илэрснээс, 4,000.0 мянган төгрөгийн зөрчилд 1 төлбөрийн акт тогтоож, зөрчлийг арилгах 13,861.7 мянган төгрөгийн 2 албан шаардлага, 1,400.0 мянган төгрөгийн 2 зөвлөмжийг хүргүүлсэн бөгөөд актыг бүрэн барагдуулж, зөвлөмжийг хэрэгжүүлсэн бөгөөд авлага барагдуулахтай холбоотой 1 албан шаардлагыг барагдуулаагүй байна.

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

2019 оны санхүүгийн тайлангийн аудитаар 3066.8 мянган төгрөгийн авлагыг барагдуулах талаар албан шаардлага өгсөн боловч одоо болтол барагдуулаагүй байгаа тул дараагийн аудитаар авч үзэх шаардлагатай.

4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 43,063.5 мянган төгрөгийн 8 алдаа зөрчил илэрснээс 5,000.0 мянган төгрөгийн 1 алдааг санхүүгийн тайланд залруулж, 955.5 мянган төгрөгийн зөрчилд 1 төлбөрийн акт тогтоож, зөрчлийг арилгах 6,134.9 мянган төгрөгийн 2 албан шаардлага, 30,973.1 мянган төгрөгийн 4 зөвлөмжийг хүргүүллээ.

4.1 Залруулга

Тус байгууллага нь "Марал гурван очир" ХХК руу худгийн карт унших тоног төхөөрөмж суурилуулахаар 5000.0 мянган төгрөг шилжүүлсэн ч одоогоор тус тоног төхөөрөмжийг хүлээн аваагүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.4 "Аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, нягтлан бодогч нь үйлдвэрлэл, үйлчилгээний шат дамжлага, аж ахуйн үйл ажиллагааны хүрээнд гарсан хөрөнгө, эх үүсвэрийн хөдлөл, өөрчлөлт бүрийг анхан шатны баримтад бичгээр болон цахимаар бичилт хийж баталгаажуулна", 20 дугаар зүйлийн 20.1.4 "хүчин төгөлдөр бус анхан шатны баримтаар, эсхүл анхан шатны баримтаар баталгаажаагүй ажил, гүйлгээг бүртгэхгүй байх" гэсэн заалтуудтай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: "Марал гурван очир" ХХК-аас 5,0 сая төгрөгийг авлагаар тусгаж, санхүүгийн тайланд залруулж, ажлыг 2022.05.01-ны дотор гүйцэтгээгүй тохиолдолд хуулийн байгууллагад шилжүүлэн, гэрээний төлбөрийг орон нутгийн орлогод төвлөрүүлэх.

4.2 Төлбөрийн акт

1. Малын гоц халдварт шүлхий өвчин тус суманд гарсантай холбоотой эргүүл постод гарсан албан хаагчдад Зурхайч адууч хоршооноос 955.5 мянган төгрөгийн тамхи

2. бичиг хэрэг, албан хэрэг хөтөлтийг байгууллагын дотоод сүлжээнд цахим хэлбэрт шилжүүлэх замаар бичиг хэрэг, цаас, хувилгагч, хэвлэгчийн хорны зэрэг зардлыг бууруулах.

дараа тооцоогоор авч бусад хангамжийн материал дансанд бүртгэн, шаардах хуудсаар олгосон байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6.4.2 дахь "төрийн чиг үүрэгт хамаарахгүй хөтөлбөр, арга хэмжээг санхүүжүүлэхгүй байх" гэсэн заалтыг зөрчсөн, санхүүгийн тайлангийн "Нийцсэн бөгөөд зохистой байх" гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Зурхайч адууч хоршоонд төлөх 955.5 мянган төгрөгийг холбогдох ажилтнуудаас суутган, өглөгийг барагдуулах төлбөрийн акт тогтоов.

4.3 Албан шаардлага

1. Тайлант хугацаанд Засаг даргын захирамжаар Засаг даргын нөөц хөрөнгөөс зарцуулсан 6134.9 мянган төгрөгийн зарцуулалтын тайланг гаргаж үр дүнг тооцоогүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.7 дахь "хөтөлбөрийн хэрэгжилтэд хяналт тавих, хүрэх үр дүнг хангаж ажиллах", Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалаар баталсан "Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам"-ын 6.2 дахь "Нөөц хөрөнгийн зарцуулалтын тайланг санхүүжүүлсэн зардал, арга хэмжээг хэрэгжүүлэх төлөвлөгөө, төсөвтэй зэрэгцүүлэн гаргаж, байгууллагын дарга, нягтлан бодогч нар гарын үсэг зурж, тамга, тэмдэг дарж баталгаажуулан холбогдох баримтыг хавсаргана" гэсэн заалтыг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Засаг даргын нөөц хөрөнгөөс зарцуулсан 6,134.9 мянган төгрөгийн хөрөнгийн зарцуулалтын тайланг гаргаж, зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлэв.

2. Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийн хүрээнд хуулийн 6.1.4-д заасан хагас жилийн санхүүгийн тайлан, 6.4.5-д заасан таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 12568.2 мянган төгрөгийн зарлагын 1 гүйлгээ, орлогын 35432.9 мянган төгрөгийн 2 гүйлгээг хугацаа хоцроож, 6.4.5-д заасан таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 44309.6 мянган төгрөгийн зарлагын 4 гүйлгээг тус тус мэдээлээгүй байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар 6.4.5 "Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр" гэсэн заалтыг зөрчсөн, санхүүгийн тайлангийн "Нийцсэн бөгөөд зохистой байх" гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.5-д заасан 44309.6 мянган төгрөгийн 4 гүйлгээг нөхөн мэдээлж, зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлэв.

4.4 Зөвлөмж

1. Тайлант хугацааны мөнгөн гүйлгээний журналыг тулгахад 5672.9 мянган төгрөгийн 17 гүйлгээг и баримт болон анхан шатны баримтын бүрдэлгүй гүйлгээ хийсэн байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1. "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно", Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.6. "Албан татвар суутган төлөгч төлбөрийн баримтыг өөр дүнгээр олгосон, эсхүл төлбөрийн баримт олгохоос татгалзсан бол албан татвар төлөгч энэ талаар татварын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад, эсхүл харьяа татварын албанд нэн даруй мэдэгдэх үүрэгтэй.", Сангийн сайдын 2017 оны 347 тоот тушаалаар батлагдсан "Өмчийн бүх хэлбэрийн аж ахуйн нэгж, байгууллагад нийтлэг хэрэглэгдэх анхан шатны бүртгэлийн маягтыг нөхөн заавар"-ын 6.5. Төлбөрийн баримт "Төлбөрийн баримт нь бараа, ажил, үйлчилгээний төлбөр, тооцоо хийгдсэнийг нотлох анхан шатны цаасан болон цахим баримт юм. Төлбөрийн баримтад борлуулагч, худалдан авагчийг таних тэмдэг, татвар

төлөгчийн дугаар, төлбөр тооцоо хийгдсэн он, сар, өдөр, бараа, ажил, үйлчилгээний нэр, код, тоо хэмжээ, үнэ, татварын дүнг тусгана. Төлбөрийн баримтыг цахим гарын үсэг эсхүл тусгай нууцлалын QR кодоор баталгаажуулах бөгөөд Монгол Улсын Стандарт MNS 6529:2015 "Татварын нэгдсэн системд ашиглах төлбөрийн баримтын ерөнхий шаардлага"-д заасан загварын дагуу бүртгэлийн машинаар хоёр хувь үйлдэнэ" гэсэн заалтуудыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Цаашид Сангийн сайдын 2017 оны "Маягт, заавар батлах тухай" 347 дугаар тушаалын холбогдох заалтыг мөрдөж ажиллаж байгаад удирдлагын зүгээс хяналт тавьж ажиллах.

2. Засаг даргын нөөц хөрөнгөөс "ТИТАНС ПИКЧУРС" ХХК-тай баримтат кино хийхээр 2535.0 мянган төгрөгийн гэрээ байгуулан 2021.09.28-ны өдөр 1000.0 мянга, 10 дугаар сард үлдэгдэл 1535.0 мянган төгрөг шилжүүлсэн байна.

Энэ нь Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоолын 1.7 дахь "... Салбарын болон байгууллагын үйл ажиллагаатай холбоотой нэвтрүүлэг, контент, баримтат болон цуврал кино зэргийг санхүүжүүлэхгүй байх" гэсэн заалттай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний талаар Засгийн газраас гаргасан тогтоол, журмуудыг хэрэгжүүлж ажиллах зөвлөмжийг хүргүүлэв.

3. Санхүүгийн тайланд оны эцэст байгууллагаас авах авлага 8,195.9 мянга, бараа үйлчилгээний зардлын өглөг 9053.8 мянга, байгууллагад өгөх өглөг 5515.5 мянган төгрөг байна

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8 дахь "төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх" гэсэн заалттай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Цаашид санхүүгийн тайланд тусгагдсан авлага, өглөгийг барагдуулж төсвийн хөрөнгийг үр ашигтай, арвилан хэмнэлттэй зарцуулж байх зөвлөмжийг хүргүүлэв.

4. 2021 оны төсвийг 353,108.7 мянган төгрөгөөр анх баталсан ба тодотголоор 62,687.1 мянган төгрөг нэмж 415,795.8 мянган төгрөгийг орон нутгийн төсвөөс, 1,000.0 мянган төгрөгийг төсөвт байгууллагын өөрийн орлогоор санхүүжүүлэхээр баталсан ба гүйцэтгэлээр 378,077.6 мянган төгрөг зарцуулж, орон нутгийн төсөвт 21,498.5 мянган төгрөгийг буцаан төвлөрүүлсэн байгаа нь нийт зардлын 5.2 хувийг хэмнэсэн.

Бичиг хэргийн зардлыг 3,123.9 мянган төгрөгөөр баталснаас бүрэн зарцуулсан, байгууллагын ашиглалттай холбоотой тогтмол зардлын төсвийг, анх баталсан дүнгээс 9,252.9 мянган төгрөг буюу 64.7 хувиар нэмэгдүүлэн тодотголоор 24,760.1 мянган төгрөгөөр баталж, гүйцэтгэлээр 23,544.9 мянган төгрөг зарцуулсан байна.

Энэ нь Засгийн газрын 2021 оны "Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай" 43 дугаар тогтоолын 1.1 "Үндсэн үйл ажиллагаатай холбоотой, зайлшгүй шаардлагатайгаас бусад бүх төрлийн зардал, төсөл, арга хэмжээг тэвчиж, зардлыг гаргахгүй байх зэргээр батлагдсан төсөвт зардлын дүнд 10-аас доошгүй хувийн хэмнэлт гаргахаар тооцож, урсгал болон хөрөнгө оруулалтын зардлыг төлөвлөн хуваарилах", 1.8 "байгууллагын цахилгаан, дулааны эрчим хүч, цэвэр усны хэрэглээнд 20-иос доошгүй хувийн хэмнэлт гаргах", 1.9 "Бичиг хэрэг, албан хэрэг хөтлөлтийг байгууллагын дотоод сүлжээнд цахим хэлбэрт шилжүүлэх замаар бичиг хэрэг, цаас, хувилагч, хэвлэгчийн хорны зэрэг зардлыг бууруулах" гэсэн заалтуудтай нийцэхгүй байна.

Хүрээмарал сумын Засаг даргын Тамгын газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Шийдвэрлэсэн нь: Цаашид төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний талаар Засгийн газраас гаргасан тогтоол, журмуудыг хэрэгжүүлж ажиллах зөвлөмжийг хүргүүлэв.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

Аудитаар өгсөн зөвлөмжийн бүрэн хэрэгжүүлж биелэлтийг нотлох баримтын хамт 2022 оны 05 дугаар сарын 30-ны дотор ирүүлнэ үү.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Хүрээмарал сумын Засаг даргын Тамгын газар	8	43,063.5	1	5,000.0	1	955.5	2	6,134.9	4	30,973.1

_____оОо_____